

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цогт сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2024/70/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2024 он	Дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 70483413 Цахим хаяг: Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn “Цэгц төв богд аудит” ХХК-ийн Ахлах аудитор Р.Цанжидмаа Утас: 99029885 Цахим хаяг: tsania.0215@gmail.com
--	---



ЦОГТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА Б.ДАШДОНДОГ
ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13, Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.23 № 65

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цогт сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Цогт сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар тендерт шалгараагүй аж ахуйн нэгжээс эмийн худалдан авалт хийсэн, бараа материалын тооллого хийгээгүй, тооцоо бодоогүй, эмийн нэр төрлийн тайлан гаргаагүй, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тээвэр, шатахууны зардалд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, зардлын эдийн засгийн ангилал зөрчин ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийг цалингийн зардлаас төлсөн, эм, бэлдмэлээс шууд зарлагадсан, хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр шагнал урамшил олгосон, тушаал, шийдвэргүй үр дүнгийн урамшуулал олгосон.

Шилэн дансны цахим системд таван саяас дээш орлого, зарлагын гүйлгээ, 6.4.8 Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээллийг мэдээлээгүй, өмнөх оны аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй зэрэг 200,739.5 мянган төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн 6.4, УСНББОУС-1-тэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт; нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Асуудлыг онцолсон хэсэг

Тус Эрүүл мэндийн төв тайлант онд Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй байгуулсан гэрээний дагуу 2361 хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.

0702900247

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээний болон нэг иргэнд ногдох санхүүжилт 550,317.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс байр ашиглалттай холбоотой зардлын санхүүжилт 29,652.1 мянган төгрөг, хандив тусламжаар 31,054.5 мянган төгрөгийн эм бэлдмэл, эмнэлгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл үнэ төлбөргүй орлого авчээ.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 4 хөтөлбөр, 48 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 39 арга хэмжээг 100.0 хувь, 4 арга хэмжээг 90.0-95.0 хувь, 5 арга хэмжээг 80.0-85.0 хувь буюу нийт дүнгээрээ 97.8 хувиар хэрэгжүүлснээр тайлагнаж, сумын Засаг даргад хүргүүлсэн боловч биелэлтийн үнэлээгүй байна. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ худалдан авах гэрээгээр 79.2 хувиар үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.М. ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мянган. төгрөг/

	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	292,204.9	306,116.2
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,629,584.9	1,562,294.5
	Нийт хөрөнгийн дүн	1,921,789.8	1,868,410.7
	Нийт өр төлбөрийн дүн		
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,921,789.8	1,868,410.7
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,921,789.8	1,868,410.7
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	2,433,435.1	611,023.8
	Үйл ажиллагааны зардлын дүн	657,880.8	663,007.0
	Үйл ажиллагааны үр дүн	1,775,554.3	(51,983.2)
	Үйл ажиллагааны бус үр дүн		1,395.9
	Үйл ажиллагааны нийт үр дүн	1,775,554.3	(53,379.1)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	146,235.5	1,921,789.8
	Тайлант оны үр дүн	1,775,554.3	(53,379.1)
	Эцсийн үлдэгдэл	1,921,789.8	1,868,410.7
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	668,414.5	571,285.5
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	513,706.4	541,633.4
	Үйл ажиллагааны ЦМГ	154,708.5	22,379.4
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(37,778.0)	(33,499.0)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	116,930.5	(11,119.5)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		116,930.5
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	116,930.5	105,811.0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан УТ			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		552,752.9
	Урсгал зардал		552,752.9
	Хөрөнгийн зардал		-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		541,633.4
	Эрүүл мэндийн даатгалын сангаас		541,633.4
	Туслах үйл ажиллагааны орлогоос		
	Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	116,930.5	105,811.0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан ОН			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		22,556.7
	Урсгал зардал		22,556.7
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		22,556.7
	Орон нутгийн төсвөөс санхүүжих		22,556.7

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 8.7 сая төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлагыг 8.7 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн.

Аудитаар залруулагдаагүй 233.9 сая төгрөгийн алдаа, зөрчилд 8 зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх, 1 хариуцлага тооцох албан шаардлага өгсөн.

5.2 Албан шаардлага

1. Зардлын эдийн засгийн ангилал зөрчин ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас төлөх 1.1 сая төгрөгийг цалингийн зардлаас төлсөн нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон аниллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана" Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал заавар"-ыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах албан шаардлага өгсөн.

2. Эм бэлдмэлээс 0.6 сая төгрөг орлого аваагүй шууд зарлага болгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэл стандартын дагуу хөтлөх албан шаардлага өгсөн.

3. Тендерт шалгараагүй 7 аж ахуйн нэгж байгууллагаас 6.4 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тендерт шалгарсан этгээдээс худалдан авалт хийж байх албан шаардлага хүргүүлсэн

4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 33.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тээвэр, шатахууны зардалд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно." Заалттай нийцэхгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Шийдвэрлэсэн нь: Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

5. Эмийн нэр төрлийн тайлан гаргаагүй, нягтлан бодох бүртгэлийн программд сарын нийт дүнгээр (124.8 сая төгрөгөөр) бүртгэл хөтөлсөн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;/, 20.2.6-т /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;/, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалын тооллого зохион байгуулж бүртгэлийг үнэн зөв болгох албан шаардлага хүргүүлсэн.

6. ЭМТ-ийн даргад Засаг даргын захирамжгүй 0.4 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2 дугаар зүйлийн 2.3-т "Энэхүү журмын 2.1-д заасан нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг энэ журмын 1.2-т заасан тухайн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан гаргана", 3 дугаар зүйлийн 3.12-т "Эрүүл мэндийн байгууллагын даргын ажлын үр дүнг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар болон тухайн албан тушаалтныг томилсон эрх бүхий албан тушаалтан дүгнэж, шийдвэр гаргана" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Эрх зүйн акт шийдвэргүй урамшуулал олгохгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

7. Бараа материалын үлдэгдэлд тооллого хийгээгүй, тооцоо бодоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;/, 20.2.6-т /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;/, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэж заасныг зөрчсөн.

8. Төрийн аудитын байгууллагаас тогтоосон 2023 оны 01/79-04/79 дугаартай албан шаардлагуудыг хэрэгжүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13-т "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах", Монгол

Цогт сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтын 19 дүгээр зүйлийн 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэж заасныг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Албан үүргээ хэрэгжүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцох

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/												
Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
Цогт сумын Эрүүл мэндийн төв	1	8.7	-	-	1	8.7	1	8.7	-	-	-	-
Дүн	1	8.7	-	-	1	8.7	1	8.7	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цогт сумын Эрүүл мэндийн төв	8	233.9	1	0.4	6	233.5	-	-	2	1	-	-
Дүн	8	233.9	1	0.4	6	233.5	-	-	2	1	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	8Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	-	-	-	1	-	-
	НИЙТ	1	1	-	-	-	1	-	-